

ҮР ДҮНТ МАНЛАЙЛАЛ:

Бусдын авьяасыг нээж илрүүл TM

Ажилтнуудад өмнөө тулгарсан асуудлаа шийдвэрлэх, өөрчлөлтөд чиглүүлэх, карьераа өсгөхөд нь туслаж чадах менежер, удирдлага нэн чухал шаардлагатай байна. Баг хамт олныг нэгтгэх, ажилтандаа урам зориг өгч, өөртөө итгэх итгэлийг өгөх нь менежер, удирдлага таны үүрэг билээ. Ажилтнуудаа татан оролцуулж, ажлаа үр дүнтэй гүйцэтгэх боломжийг олгох нь чухал. Өнөө үед илүү нөлөөлөлтэй, хүлээн зөвшөөрөгдсөн менежер, удирдлага байхын тулд та өөрийгөө мөн дараагийн түвшинд гаргах шаардлага бий болсон байна.

Дэйл Карнегийн харилцаа төвтэй манлайллыг хөгжүүлэх өвөрмөц арга барил бүхий энэхүү хөтөлбөр таныг илүү нөлөөлөлтэй, урам зориг бүхий чадварлаг удирдагч болоход тань туслах болно.

Хөтөлбөрийн зорилтууд:

- Бусдад урам өгч, зоригжуулан, хөгжүүлэх
- Багийн ажиллагаа, хамтын ажиллагаа, инновацыг дэмжих
- Байгууллага дотор үр дүнтэй харилцаа бий болгох
- Өөрчлөлтөд бусдыг чиглүүлэх

Манлайллын үр чадварууд:

Өөрийгөө таньж мэдэх

- Өөртөө итгэх итгэл

Хариуцлагатай байдал

- Үнэнч шударга байх
- Зорилгодоо хүрэх, ахиц дэвшлийг бий болгох
- Үр дүнтэй шийдвэр гаргах

Бусдад төвлөрөх

- Урам зориг өгөх
- Үр дүнтэй харилцах
- Багаар ажиллах, хамтын ажиллагааг дэмжих
- Ажилтны оролцоог дэмжих
- Өөрчлөлтөд хөтлөх
- Хамтран ажиллах

Стратеги

- Шинэлэг байх
- Асуудлыг шийдвэрлэх
- Урагш төвлөрөх

Хаяг:

Фидес цамхаг, 8 давхар, 802 тоот, Гэгээнтэн цогцолбор, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс

Хэн оролцох вэ?

Өөрийн болоод багийн чадавхи, гүйцэтгэлийг дараагийн шатанд гаргах хүсэлтэй удирдлага, менежерүүд.


Холбогдох:

Дэйл Карнеги Трэйнинг Монгол
Утас: 7000-0330

info@dalecarnegie.mn
www.dalecarnegie.com

Гүйцэтгэлийн өөрчлөлтийн зураглал®

Дэйл Карнегийн хөтөлбөр нь сургалтад ирсэн оролцогчдыг анх ирсэн цагаас нь эхлэн хөтлөн дэмжих замаар амжилтад хөтлөх гол зан чанаруудыг нь хөгжүүлэх хэлбэрээр явагддаг. Бидний арга барил оролцогчийн гүйцэтгэлийн өөрчлөлтийг тогтоон барих ур чадвар болон хэвшлийг хөгжүүлэхэд оршино. Сэтгэл хөдлөлийн өөрчлөлт нь зан харилцааны өөрчлөлтөөс дутуугүй чухал гэдэгт бид итгэдэг. Манай сургалтын хөтөлбөр хэрхэн гүйцэтгэлийг сайжруулахад чиглүүлдэг болохыг энэхүү гүйцэтгэлийн өөрчлөлтийн зураглал харуулж байна.



“Дэйл Карнегийн Гүйцэтгэлийн өөрчлөлтийн зураглал” гол таван түлхүүр бүрдэл хэсгээс бүрдэнэ. “Орц, Ойлголт, Туршлага, Тогтоох, Гарц”. Эдгээр бүрдэл хэсгүүд нь манай хөтөлбөрийн хүргэлтийн арга барилын загварчлалд чухал ач холбогдолтой бөгөөд оролцогчдын үргэлжлүүлэн суралцах замыг заан өгч, байгууллагын үр дүнд хөтөлдөг.

Үр дүнт манлайлал: Бусдын авьяасыг нээж илрүүл
– Leadership Training Result: Unleash Others Talent

№		Суралцах зүйлс
1	Үр дүнтэй багийг бүрдүүлэх нь	- Дэйл Карнегийн гаргасан Амжилтад хөтлөх манлайллын загварт дүн шинжилгээ хийх - Багт үр дүн бүтээх стратегийг хэрэгжүүлэх - Хувийн алсын хараа, багийн зорилгын мэдэгдэл гаргах - Үлгэр дуурайлал болохуйц манлайлагч болоход туслах манлайллын ур чадваруудыг тодорхойлох
2	Инновац	- Гүйцэтгэлд бий болсон гажуудлыг инновац болгон хувиргахын тулд харилцааны зарчмуудыг хэрэгжүүлэх - Үр дүнг сайжруулахын тулд инновацын үйл явцыг хэрэгжүүлэх - Инновацын төлөвлөгөө боловсруулах
3	Гүйцэтгэл ба үр дүн	- Гүйцэтгэлийн үр дүнгийн зураглал үүсгэж эхлэх - Зорилгодоо хүрэх үйл явцыг хянах аргуудыг тодорхойлох - Нөлөөлөлт манлайллын төлөвлөгөөг үргэлжлүүлэн боловсруулах “Хүмүүсээ нэн тэргүүнд тавих” соёлоор дамжуулан зорилго, стратегийг уялдуулах, дамжуулах мөн төлөвлөгөө боловсруулах
4	Хүмүүсээ нэн тэргүүнд тавих	- Ажилтанд энгэйжмент төрүүлэх болон бүтээмжид нөлөөлөх бусад хүчин зүйлсийг тодорхойлох - Ажилтны энгэйжментийг дэмжих арга техник ашиглах
5	Ажил даалгах үйл явц	- Бусдаар ажил гүйцэтгүүлэх арга техникийг ашиглах, багийн гишүүдийн авьяас чадварыг хөгжүүлэх - Ажлыг үр дүнтэй даалгах загвар ашиглах
6	Өөрчлөлтөд нээлттэй ханддаг хүмүүс	- Удирдагч хүний авч хэрэгжүүлэх ёстой алхмуудыг тодорхойлсон - Инновацын үйл явцын загвартай танилцах - Өөрчлөлтийг ажилтнуудаар хүлээн зөвшөөрүүлэх арга техниктэй танилцах - Өөрчлөгдөх өөр өөр төрлийн хэв шинж байдгийг олж мэдэх - Өөрчлөлтийг эсэргүүцсэн хариу үйлдэлд үр дүнтэй байдлаар хариу өгөх
7	Ололт, амжилтаа тэмдэглэх	- Инновацын төлөвлөгөөг үргэлжлүүлэн хөгжүүлэх - Өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд анхаарах чухал асуудлуудыг тодорхойлох - Инновацын төлөвлөгөөг хүлээн зөвшөөрүүлэхэд бэлтгэх